



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/490

Булган сум

**Гэрээ байгуулах эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтаргана 2024” олон улсын XV их наадмын хүрээнд Хөгжимт жүжгийн театрын техник, тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр “Алтай цагаан хайрхан” ХХК-ийг сонгож, 19,580,000 (арван есөн сая найман зуун тавин мянга) төгрөгөөр хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулах эрхийг Хөгжимт жүжгийн театрын дарга (О.Ууганчимэг)-д олгосугай.

2. Гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

3. Дээрх хөрөнгийг хавсралтаар баталж, орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

4. Гэрээний биелэлтийн дагуу техник, тоног төхөөрөмжийг бүртгэлжүүлж тайлагнахыг Хөгжимт жүжгийн театрын дарга (О.Ууганчимэг)-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010651

07 дүгээр сарын 04 ны өдрийн 07/090 дугаар захирамжийн хавсралт



Хөгжимт жүжгийн театрын техник, тоног төхөөрөмжийн зардлын тооцоо

Д/д	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1.	2	3	4	5
1.	Гэрлийн аналог пулт /SUNNY DMX512/	1ш	1,000,000	1,000,000
2.	Чанга яригч /JBL SRX835/ өөр дээрээ чадалтай	2ш	5,000,000	10,000,000
3.	Зайны микрофон /SHURE QLX-D/	3ш	900,000	2,700,000
4.	Лед гэрэл	15ш	300,000	4,500,000
5.	Сигнал кабель /Belden YJ 56/	100м	8,000	800,000
6.	Холбогч толгой /Neutrik XXL, XLR/	20 хос	20,000	400,000
7.	AUX холбогч	3ш	60,000	180,000
Нийт дүн			19,580,000	